

Патриархын адислалын талаарх асуултуудад хариулах

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн хуваалцсан.



[Патриархын адислал] бол нандин билээ. Энэ бол таны хувийн судар юм. Энэ нь таны онцгой угсаа овгийг тунхаглаж, өнгөрсөн үетэй хэрхэн холбогдож байгааг тань сануулдаг. Мөн энэ нь ирээдүйн чадавхаа ойлгоход тань тусална. Шууд утгаараа, та итгэлтэй байснаар тэдгээр адислал биелэгдэхийг Их Эзэнээс шаардаж болно гэсэн үг юм. (Russell M. Nelson, "Thanks for the Covenant" [Brigham Young University devotional, Nov. 22, 1988], 5)

Далын ахлагч Казухико Ямашита ийн гэрчилсэн.



Би патриархын адислалаа тогтмол, залбиралтай уншдаг бөгөөд энэ нь надад үргэлж урам зориг өгдөг. Би Их Эзэн надаас юу хүсэн хүлээдгийг ойлгодог бөгөөд энэ нь намайг наманчилж, даруу байхад тусалдаг. Би үүнийг уншиж, тунгаан бодох үедээ амласан адислалуудыг хүлээн авахуйц зөв зохистой амьдрахыг хүсдэг. . . .

. . . Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайрт, Эцэгийн Төрсөн Ганц Хүү, Их Эзэн Есүс Христ амьд гэсэн гэрчлэлээ би хуваалцаж байна. Тэд бидэнд хайртай. Патриархын адислал нь

Тэдний ариун бэлэг юм. Та адислалаа авахдаа, Тэд таныг хэрхэн хайрлаж, хувьчлан анхаарал хандуулдгийг ойлгох болно. (Казухико Ямашита, "Патриархын адислалаа хэзээ авах вэ," *Лиахона*, 2023 оны 5-р сар, 88–90)

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Бонни Х.Кордон ийн хуваалцсан.



Нэгэн ӨҮБББТ чуулганы үеэр би хэцүү байдалтай тулгарсан хоёр залуу эмэгтэйтэй уулзсан. Тэр хоёр хоёулаа патриархын адислалаа эргэн харж, өөрсдөд нь хувьчлан хандсан Их Эзэний хайр, удирдамжийг дахин олж мэдсэнээ дурдсан юм. Патриархын адислалаа олж гаргаад, тоосонд дарагдсан байвал арчиж, үргэлж судалж байгаарай. Патриархын адислалаа аваагүй бол хурдхан аваарай. Та нарын хэн болох талаар Их Эзэний юу хэлэхийг хүсэж байгааг олж мэдэхээ бүү хойшлуул. (Бонни Х.Кордон, "Христэд ир, гэхдээ ганцаараа бүү ир," *Лиахона*, 2021 оны 11-р сар, 10–12)